

НОМЫН ШҮҮМЖ

Pax Mongolica №1, 2016 он: 144-145 хуудас

“ХУБИЛАЙ ХААНЫ МӨНХ ТЭНГЭРТ ӨРГӨСӨН БИЧИГ” НОМЫН ШҮҮМЖ

Ц.Лхам¹

Монголын их өвөгт олон мянган жилийн тэртээгээс өмнө зүг нүүж, жаргалыг олохын төлөө зүтгэснийг Хубилай хаан бээр хэрхэн хэрэгжүүлсэн тухайгаа 1293 онд их өвөг дээдэс болон мөнх тэнгэртээ мэдэгдэн өргөсөн бичгийг анх удаа олж тайлан, шинжлэх ухааны эргэлтэнд оруулж буй гэдгээрээ “Хубилай хааны мөнх тэнгэрт өргөсөн бичиг” хэмээх номын ач холбогдол цаглашгүй их юм.

Хубилай хаан 1258-1294 онд хаан ширээнд суух хугацаандаа, өмнөх хаан өвгийн тогтоосон хил хязгаарыг умар тийш цааш тэлэн нэмсэн, баруун зүгт Персийн булан хүртэл, зүүн тийш Солонгосын хойг, өмнө зүг Вьетнамыг давуулан тэлсэн төдийгүй энэ уудам их орон зайд алаан хядааныг зогсоож, муу муухайг арилган, язгуурын ёсыг сэргээн, энэрэл нигүүлснийг үзүүлсэн тухайгаа Хубилай хаан тэнгэрт халихынхаа өмнөхөн буюу 1293 онд их өвөг дээдэстээ өчин мэдэгдсэн эл бичиг нь харахад 29,7х42 см-ийн хэмжээтэй алтан дээр дөрвөлжин хятад болон хятад ханз хоёр зүйлийн үсгээр бичигдсэн, уг бичвэрийн дээд талд луу, аварга могой, бичвэрийн доод талд хос загас товойлгон сийлсэн байдалтай байна.

Түүхийн энэхүү ховор нандин дурсгалт бичгийг ШУА-ийн Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн захирал проф. доктор (Sc.D) Ж.Баясах 2014 оноос эхлэн гардан судалж, улмаар уг судалгааны үр дүнг ном болгон хэвлүүлснээ 2015 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр

1. ШУА-ийн Олон Улсын харилцааны хүрээлэнгийн судлаач

“Хубилай хааны мөнх тэнгэрт өргөсөн бичиг” номын шүүмж

Монголын эзэнт гүрний их хаан Хубилай сэцэний мэндэлсний 800 жилийн түүхт их ойг тэмдэглэх ёслолын үеэр Улаанбаатар хотноо олон нийтэд анхлан танилцуулсан билээ. Уг ном нь нийт 19 зүйл, хавсралт бүхий 80 хуудастай. Энэхүү бүтээлийг цаашид олон хэлнээ орчуулж, дэлхий дахины хүртээл болговоос зохистой гэж үзнэм.